

АЖ ТОРОХ
УХААН

Г.Ловор

ТАЛД УРГАДАГ ТАЛХ



З-Р
ангийнханд
зориулав

**Г.Ловор
Талд ургадаг талх**

Бага сургуулийн 3-р ангийн сурагчдад зориулав.

| | |
|------------------------|---------------|
| Зураач | Л.Зулбадрах |
| Хянан тохиолдуулагч | Д.Сугархүү |
| Хянагч | О.Мөнхтүяа |
| Хэвлэлийн эх бэлтгэсэн | Ж.Гэрэлмаа |
| | Н.Хөдөлмөр |
| | Д.Хишигдэлгэр |



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Талд ургадаг талх

Бид талханд дуртай. Ээж дэлгүүрээс талх худалдаж авчирсан нэгэн өдөр хэрэг мандлаа. Бид хоёр цангасан адуу ус уруу дайрах шиг талхаа булаацалдав. "Талхны буланг хэн идэх вэ?" гэдгээс тэр л дээ.



Тэгтэл аав орж ирэв. Ширээгээр нэг тарсан талхны үйрмэгийг алгандаа цуглуулж аваад,

- Энэ юу вэ? гэж бид хоёроос асуулаа.
- Талхны хог...
- Хог гэнэ ээ! Хоолоо хог болгож болохгүй ээ гээд бид хоёрыг харав.

- Талхыг дэлгүүрт ургадаг гэж санаж байна уу? гэж аав зэмлэх аятай асуув. Чухам үүнээс үүдэж талхыг яаж хийдгийг ааваар яриулахад хүрэв.
- Талх хийхийн тулд эхлээд газар хагална гэж аавыг хэлэв үү, үгүй юу дүү маань,

- Талх газраас гардаг юм уу? гэж инээд хургэв.



Тэгтэл аав:

- За бараг тийм дээ. Чи эхлээд анхааралтай сонс. Талх хийдэг гурил газарт ургадаг биз дээ гэхэд дүү маань бүр гайхаж байгаа бололтой, нүдээ бүлтийлгэв. Би ч гурилыг газраас авдаг гэхэд эргэлзэв.

- Хавар газраа хагалж, хөрсийг зөөллөн борнойдож, үндсийг самнана. Дараа нь үр цацаж, суулгана даа гэсэнд дүү маань:

- Талх үрнээс гардаг юм байна шүү дээ гэж тэсэлгүй дуу алдлаа.

- Тийм ээ, үрээ сайн ургуулахын тулд бас газрын хөрсөнд бордоо хийх хэрэгтэй.



Үүний ачаар үр соёолно. Үр томорч олон салаа тариа болно.

Дүү маань үнэн санаанаасаа,
- Тэгээд талх ургачих нь байна шүү дээ гэж амандаа
бувтнав.
- Болоогүй ээ, тариалсан хүн талбайдаа мал адгуус
оруулалгүй харж, хамгаалж, байнга усалж тордоно.
Тэгж байж ургасан тариагаа намар хураана.




Эртцагтхүмүүстариагаагараартасалжавахгэжтүмэн зовлон эдэлдэг байсан. Одоо комбайнаар хураачихна. Хураасан тариагаа гурилын үйлдвэрт хүргэж тушаана. Тэнд л үрийг няцалж гурил болгоно доо гэхэд дүү маань:

- Тэгээд талх гарах юм уу? гэж дахин шалгаав.
- Бас болоогүй, тэндээс гарсан гурилаа талхны үйлдвэрт түгээж байж сая талх болгоно доо. Дугуй, дөрвөлжин, загасан талх, тэр ч байтугай терөл бүрийн жигнэмэг, гоймон хүртэл бэлдэнэ. Тэндээс гарсан талх, бусад бүтээгдэхүүн бас л бидний гар дээр ирэхгүй ээ. Ачигдаж дэлгүүрт очсон талхыг тухайлбал, зэж чинь тэндээс худалдаж авдаг юм. Ямар олон хүний хүч, хөдөлмөр зардал орж хийгддэгийг одоо ойлгов уу? гэж асуув.

Бид аавын энэ ярианаас хойш талхаа булаацалдаж үйрүүлдэгээ больж, үйрмэгээ ч иддэг болж билээ.



Бага сургуулийн 3-р ангийнханд зориулав.



Хүн өөрөө төдийгүй өрөөл олон түмний хүчээр ажиллах, амьдрах орчин ахуйгаа хамтран бүтээдэг.



Хүний гол хүнс талх, боов хамт олны хүч хөдөлмөрөөр буй болдог.



Байгууллага хүмүүсийн хоорондын харилцан үйлчилгээ бол нийтээр тохиолог амьдрах, аж төрөх, улмаар нийгэм хөгжих боломж бүрдүүлдэг.



Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бизнес эрхлэгч хэн ч бай, түүний үр ашгийг урьдчилан тооцоолж, сонголтоо зөв хийх нь чухал.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.